

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндун сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: *ДОА-2021/2/СТА-ТШЗ*

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203

Аудитын менежер:

Утас: 7058-4207

Аудитор:

Утас: 7000-3775

Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

И.Сэмжидмаа

Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Э.Нандинчимэг

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ДОА	Дорнод аймаг
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд



Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	10
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.9. Аудитын илрүүлэлт.....	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	11
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13

1. Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 289

танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баяндун сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Дорнод аймгийн Баяндун сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Дорнод аймгийн Баяндун сумын цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020253



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,031,283.09	46,235,183.09
35	БАРАА МАТЕРИАЛ	43,031,283.09	46,235,183.09
354	Хангамжийн материал	43,031,283.09	46,235,183.09
35410	Бичиг хэргийн материал	4,320,500.00	4,320,500.00
35420	Аж ахуйн материал	19,837,063.00	19,837,063.00
35460	Хүнсний материал	-	3,251,900.00
35470	Бусад хангамжийн материал	18,873,720.09	18,825,720.09
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	980,108,349.08	945,335,405.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	980,108,349.08	945,335,405.66
392	Биет хөрөнгө	962,919,849.20	928,339,405.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	916,263,576.13	916,263,576.13
39202	Хуримлагдсан элэгдэл	(48,943,164.07)	(69,227,924.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00
39204	Хуримлагдсан элэгдэл	(3,000,000.00)	(3,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,055,789.50	67,398,824.50
39206	Хуримлагдсан элэгдэл	(22,829,444.00)	(29,993,381.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,783,541.00	65,357,613.50
39208	Хуримлагдсан элэгдэл	(22,074,421.47)	(35,683,976.31)
39209	Зам, гүүрийн байгууламж	20,612,936.95	20,612,936.95
39210	Хуримлагдсан элэгдэл	(3,242,314.84)	(6,681,613.00)
39217	Ном	293,350.00	293,350.00
393	Биет бус хөрөнгө	17,188,499.88	16,996,000.00
39301	Програм хангамж	1,100,000.00	1,100,000.00
39302	Хуримлагдсан элэгдэл	(907,500.12)	(1,100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,996,000.00	16,996,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,023,139,632.17	991,570,588.75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	320,412.89	-
41	БОГИНО ХУГААЦААТ ӨР ТӨЛБӨР	320,412.89	-
413	Өглөг	320,412.89	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	320,412.89	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,022,819,219.28	991,570,588.75
51	Засгийн газрын хувь оролцоо	1,022,819,219.28	991,570,588.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	741,821,165.00	741,821,165.00
51101	Өмч - төрийн	741,821,165.00	741,821,165.00
512	Хуримлагдсан үр дүн	245,380,656.63	214,132,026.10
51210	Өмнөх үеийн үр дүн	245,380,656.63	245,380,656.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	(31,248,630.53)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	35,617,397.65	35,617,397.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	1,023,139,632.17	991,570,588.75



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	445,945,963.00	461,003,107.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,305,563.00	10,007,007.50
120	Нийтлэг татварын бус орлого	57,305,563.00	10,007,007.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,305,563.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,305,563.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		9,917,107.50
120012	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа матернал		89,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	388,640,400.00	450,996,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	353,720,000.00	412,181,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,720,000.00	412,181,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,420,400.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,420,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,500,000.00	38,815,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,500,000.00	38,815,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	449,929,126.83	492,251,738.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	449,929,126.83	492,251,738.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,670,067.42	477,263,498.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,793,676.55	320,061,699.30
210101	Үндсэн цалин	236,025,428.55	254,797,384.30
210102	Нэмэгдэл	7,996,500.00	48,775,500.00
210104	Урамшуулал	20,771,748.00	16,488,815.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,917,652.93	39,687,487.11
210201	Тэтгэврийн даатгал	21,699,443.45	26,884,887.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,497,762.28	3,200,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,106,312.38	2,560,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	510,467.24	640,200.00
210205	Эрүүд мэндийн даатгал	5,103,667.58	6,401,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,546,794.00	31,390,646.06
210301	Гэрэл, цахилгаан	14,651,914.10	15,849,430.06
210302	Түлш, халаалт	8,069,879.90	14,491,216.00
210303	Цэвэр, бохир ус	825,000.00	1,050,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,410,798.00	7,027,500.00
210401	Бичиг хэрэг	1,133,340.00	927,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,350,000.00	757,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,125,000.00	193,400.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,752,458.00	5,048,800.00
2105	Нормативт зардал	50,777,930.00	29,380,915.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,600.00	797,600.00
210502	Хоол, хүнс	50,630,330.00	28,583,315.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,750,000.00
210604	Урсгал засвар	-	3,750,000.00
2107	Томилголт, зочны зардал	150,000.00	128,000.00
210702	Лотоол албан томилголт	150,000.00	128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,600,400.00	369,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,600,400.00	133,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	236,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,472,815.94	45,467,350.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	572,250.00	777,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,900,565.94	44,690,050.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,259,059.41	14,988,239.64
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,259,059.41	14,988,239.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,259,059.41	14,988,239.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(3,983,163.83)	(31,248,630.53)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,152,311.44	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарс	12,152,311.44	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(12,152,311.44)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(16,135,475.27)	(31,248,630.53)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	388,640,400.00	450,996,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	388,640,400.00	450,996,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	353,720,000.00	412,181,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,720,000.00	412,181,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,420,400.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,420,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,500,000.00	38,815,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,500,000.00	38,815,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	388,640,400.00	450,996,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	388,640,400.00	450,996,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	381,381,340.59	436,007,860.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,657,334.05	320,061,699.30
210101	Үндсэн цалин	224,880,800.00	254,797,384.30
210102	Нэмэгдэл	14,126,766.43	48,775,500.00
210104	Урамшуулал	25,649,767.62	16,488,815.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,800,412.54	40,007,900.00
210201	Тэтгэврийн даатгал	21,803,931.02	27,205,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,276,034.32	3,200,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,106,312.38	2,560,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	510,467.24	640,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,103,667.58	6,401,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,771,794.00	31,390,646.06
210301	Гэрэл, цахилгаан	12,696,861.10	15,849,430.06
210302	Түлш, халаалт	10,024,932.90	14,491,216.00
210303	Цэвэр, бохир ус	1,050,000.00	1,050,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,665,900.00	7,010,900.00
210401	Бичиг хэрэг	414,200.00	821,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,100,000.00	757,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,125,000.00	193,400.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	926,700.00	5,138,700.00
2105	Нормативт зардал	50,646,100.00	32,632,815.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,600.00	797,600.00
210502	Хоол, хүнс	50,498,500.00	31,835,215.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,750,000.00
210604	Урсгал засвар	-	3,750,000.00
2107	Томиллолт, зочны зардал	150,000.00	128,000.00
210702	Дотоод албан томиллолт	150,000.00	128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,600,400.00	386,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,600,400.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	236,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,089,400.00	639,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,089,400.00	639,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,259,059.41	14,988,239.64
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,259,059.41	14,988,239.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,259,059.41	14,988,239.64
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхсийн үлдэгдэл		



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	245,380,656.63	0.00	1,022,819,219.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	245,380,656.63	0.00	1,022,819,219.28
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	245,380,656.63	0.00	1,022,819,219.28
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	245,380,656.63	0.00	1,022,819,219.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	245,380,656.63	0.00	1,022,819,219.28
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-31,248,630.53	0.00	-31,248,630.53
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	741,821,165.00	35,617,397.65	214,132,026.10	0.00	991,570,588.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	383,220,000.00	375,960,940.59	502,239,700.00	436,007,860.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	383,220,000.00	375,960,940.59	502,239,700.00	436,007,860.36
210	БАГАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,220,000.00	375,960,940.59	502,239,700.00	436,007,860.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,878,800.00	264,657,334.05	320,061,900.00	320,061,699.30
210101	Үндсэн цалин	224,880,800.00	224,880,800.00	261,134,700.00	254,797,384.30
210102	Нэмэгдэл	14,348,000.00	14,126,766.43	48,775,500.00	48,775,500.00
210104	Урамшуулал	25,650,000.00	25,649,767.62	10,151,700.00	16,488,815.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,109,800.00	31,800,412.54	40,007,900.00	40,007,900.00
210201	Тэтгэврийн даатгал	22,514,400.00	21,803,931.02	27,205,200.00	27,205,300.00
210202	Гэтгэмжийн даатгал	2,648,700.00	2,276,034.32	3,200,400.00	3,200,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,119,200.00	2,106,312.38	2,560,700.00	2,560,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	529,900.00	510,467.24	640,200.00	640,200.00
210205	Эрүүд мэндийн даатгал	5,297,600.00	5,103,667.58	6,401,400.00	6,401,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,500,000.00	23,771,794.00	35,900,500.00	31,390,646.06
210301	Гэрэл, цахилгаан	13,120,500.00	12,696,861.10	18,813,500.00	15,849,430.06
210302	Түлш, халаалт	15,329,500.00	10,024,932.90	16,037,000.00	14,491,216.00
210303	Цэвэр, бохир ус	1,050,000.00	1,050,000.00	1,050,000.00	1,050,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,665,900.00	3,665,900.00	2,499,900.00	7,010,900.00
210401	Бичиг хэрэг	444,200.00	414,200.00	521,200.00	821,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,100,000.00	1,100,000.00	770,000.00	757,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,125,000.00	1,125,000.00	180,000.00	193,400.00
210404	Ном, хэвлэл	70,000.00	100,000.00	100,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	926,700.00	926,700.00	928,700.00	5,138,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал				
2105	Нормативт зардал	50,646,100.00	50,646,100.00	98,900,100.00	32,632,815.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,600.00	147,600.00	147,600.00	797,600.00
210502	Хоол, хүнс	50,498,500.00	50,498,500.00	98,752,500.00	31,835,215.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	-	-	3,750,000.00	3,750,000.00
210604	Урсгал засвар	-	-	3,750,000.00	3,750,000.00
2107	Томиллот, зочны зардал	150,000.00	150,000.00	150,000.00	128,000.00
210702	Дотоод албан томиллот	150,000.00	150,000.00	150,000.00	128,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00	180,000.00	330,000.00	386,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	150,000.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00	180,000.00	236,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,089,400.00	1,089,400.00	639,400.00	639,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	1,089,400.00	1,089,400.00	639,400.00	639,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	383,220,000.00	383,220,000.00	502,239,700.00	450,996,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	353,720,000.00	353,720,000.00	463,424,700.00	412,181,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	353,720,000.00	353,720,000.00	463,424,700.00	412,181,100.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих				
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих				
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих				
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,500,000.00	29,500,000.00	38,815,000.00	38,815,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	29,500,000.00	29,500,000.00	38,815,000.00	38,815,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг И.Эрдэнэцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ы хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баяндун сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баяндун сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль бусад холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаалын шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон цэцэрлэгийн насны хүүхдийг асрах, хамгаалах цогц үйл ажиллагаагаар бие бялдар, оюун ухааныг нийгэмшүүлэн хөгжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баяндун сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Баяндун сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож,

эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 492,252.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 9,845.0 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баяндун сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,569.1 мянган төгрөгөөр буюу хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	43,031.2	46,235.1	3,203.9
Үндсэн хөрөнгө	1,081,105.2	1,091,022.3	9,917.1
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-100,996.8	-145,686.9	-44,690.1
Нийт хөрөнгө	1,023,139.6	991,570.5	-31,569.1
Өр төлбөр	320.4	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,023,139.6	991,570.5	-31,569.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,023,139.6	991,570.5	-31,569.1

Бараа материалын дансны үлдэгдэл 46,235.1 мянган төгрөг болж 3,203,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материал, сургалтын хэрэгсэл авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,091,022.3 мянган төгрөг болж 9,917.1 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр хандив болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 9,917.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Баяндун сумын цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 15,057.1 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 42,322.6 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 502,239.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 502,239.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 502,239.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 502,239.7 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 412,181.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс мянган төгрөгийг 38,815.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 450,996.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 436,007.9 мянган төгрөгийг зарцуулж 14,988.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 436,007.9 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өөрийн үйл ажиллагаанаас орлого байхгүй.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээлэл оруулснаас хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа хоцорсон 13 мэдээлэл байна. Батлагдсан төсвийн 259,339.6 мянган төгрөг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 гүйлгээний 5,894.6 мянган төгрөгийн мэдээлэл нийт 264,234.2 мянган төгрөгийн мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцорч байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1457,0 мянган төгрөгийн төлбөрийн актыг 2020 онд бүрэн барагдуулж дууссан, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 969,155.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 969,155.5 мянган төгрөгийн зөрчилд 351.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 968,803.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 969,155.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 969,155.5 мянган төгрөгийн зөрчилд 351.8 мянган төгрөгийн төлбөрийн акт 1 тогтоож, 968,803.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 351.8 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хууль Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Худалдан авалтын үнийн гэрээний үнэ болон тендерийн үнийн саналтай харьцуулахад 11,899.7 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн

41 дүгээр зүйлсийн 2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны эцэст 928,339.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогыг хангалтгүй чанаргүй хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд гарсан зардлаас 28,564.6 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Дорнод аймгийн Баяндун сумын цэцэрлэг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДОА-2021/2/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дорнод аймгийн Баяндун сумын цэцэрлэг	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тооллогын бүртгэл хангалтгүй тулгах боломжгүй. Жилийн эцэст Санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн дүн 928,339.4 мянган төгрөг байна. 35410 дансанд бичиг хэргийн материал, ном 2-ыг хольж бүртгэсэн. Номын бүртгэлийг залруулах, 1 ном 2,000.0 мянган төгрөг гэж бүртгэсэн байна.	928,339.4	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	И.Эрдэнэцэцэг Б.Оюунбат
2	Нийт 145 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр) 1 мэдээлэл оруулаагүй, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр 9 сард) 259,339.6 мянган төгрөгийн 1 мэдээлэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр 6 ба 10 сард) 5,894.6 мянган төгрөгийн 2 мэдээлэл, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр 9 ба 11 сард), Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр 9 сард) 1 мэдээлэл, Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр) 1 мэдээлэл оруулаагүй, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр 9 ба 11 сард), Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа		Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	И.Эрдэнэцэцэг Б.Оюунбат



	шийдвэр (Тухай бүр 9 сард), Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр 9 ба 11 сард) гэсэн нийт 13 мэдээллийг хугацаа хоцорч оруулсан байна.				
3	Баян-Эрхэт Улз ХХК-тай нүүрс тээврийн гэрээ байгуулж 264.1 тн нүүрсийг 4,016.0 төгрөгөөр худалдан авсан. Хүүхдийн хоол хүнсэнд тендер зарлан Дээшлэх нар ХХК шалгарч бүтээгдэхүүний нийлүүлсэн ба үнийн санал болон худалдан авалт хийсэн үнийг харьцуулахад тендерийн үнийн саналд ирүүлээгүй 11,899.7 мянган төгрөгийн бүтээгдэхүүн худалдаг авсан байна.	11,899.7	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	И.Эрдэнэцэцэг Б.Оюунбат
4	Харилцахаас 75,527.3 мянган төгрөгийн зардал төлөгдсөнөөс 28,564.6 мянган төгрөгийн баримт татварын цахим системд бүртгэгдээгүй байна.	28,564.6	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	И.Эрдэнэцэцэг Б.Оюунбат
5	Батлагдсан төсөв 757.6 мянган төгрөг бөгөөд тайлант хугацааны зарцуулалт батлагдсан төсвөөс хэтрээгүй ч АШБ бүрдэлгүй 330.0 мянган төгрөг, жишиг нормоор тооцоолоход 21.8 мянган төгрөгийн илүү зарцуулалттай байна.	351.8	Төлбөрийн акт тогтоох	Цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	И.Эрдэнэцэцэг Б.Оюунбат
ДҮН		969,155.5			